



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/81/НА-СТА-ТШЗ

| | |
|--------------------------------------------------------------|-------------------------------------------------------|
| Цахим хуудас: www.audit.mn | Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, |
| Булган аймаг | тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ |
| 2023 он | Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Ж.Энхцоодол |
| | Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: Г.Намчинсүрэн |
| | Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---------------------------------------------------------------------------|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 4 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 6 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 14 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 18 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 18 |
| 4.2 Материаллаг байдал..... | 18 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 18 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 18 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 19 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 20 |
| 5.1 Төлбөрийн акт..... | 20 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 21 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120.
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.14 № 68
танай _____ ны № _____ т

САЙХАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.ЛХАГВАДОРЖ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.12-д хязгаарлалтад хамрагдаагүй.

Булган аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургууль 1 хөтөлбөр, 13 арга хэмжээний хүрээнд нийт 1,474,972.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,374,739.4 мянган төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 93.2 хувьтай байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020069

Сайхан сумын ерөнхий боловсролын төсвийн шууд захирагч нь 2022 онд Сайхан сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 88 хувийн биелэлтэйгээр тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>80,169,191.80</u> | <u>162,744,634.38</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 101,227,713.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 101,227,713.00 |
| 3121 | Төгрөг | - | 101,227,713.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 101,227,713.00 |
| 33 | АВЛАГА | 16,063,000.00 | - |
| 335 | Бусад авлага | 16,063,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 16,063,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 64,106,191.80 | 61,516,921.38 |
| 351 | Түүхий эд материал | 702,150.00 | 2,996,112.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 2,930,412.00 |
| 35130 | Эм боох материал | 702,150.00 | 65,700.00 |
| 354 | Хангамжийн материал | 63,404,041.80 | 58,520,809.38 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,711,950.00 | 1,931,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 56,346,271.05 | 43,393,274.83 |
| 35450 | Барилгын засварын материал | 246,000.00 | 75,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,099,820.75 | 13,120,634.55 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>2,165,437,379.81</u> | <u>2,070,391,861.64</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,165,437,379.81 | 2,070,391,861.64 |
| 392 | Биет хөрөнгө | 2,137,022,479.81 | 2,041,539,461.64 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,354,452,129.74 | 2,357,452,129.74 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (391,670,129.08) | (515,910,373.60) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 9,500,000.00 | - |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (9,500,000.00) | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 131,706,116.43 | 119,906,414.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (74,478,217.39) | (32,873,412.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 130,320,597.98 | 132,563,297.58 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (49,220,165.39) | (56,107,741.54) |
| 39217 | Ном | 35,912,147.52 | 36,509,147.52 |
| 393 | Биет бус хөрөнгө | 28,414,900.00 | 28,852,400.00 |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 2,880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (337,500.00) | (1,430,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 27,402,400.00 | 27,402,400.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>2,245,606,571.61</u> | <u>2,233,136,496.02</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,966,099,801.93</u> | <u>2,233,136,496.02</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,966,099,801.93 | 2,233,136,496.02 |

| | | | |
|------------|--------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 279,506,769.68 |
| 51101 | Өмч: - төрийн | | 279,506,769.68 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 49,117,124.82 | 58,290,068.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 49,117,124.82 | 70,760,143.62 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (12,470,075.59) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,916,982,677.11 | 1,895,339,658.31 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,966,099,801.93 | 2,233,136,496.02 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,132,717,976.52 | 1,497,258,344.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 13,156,884.52 | 22,286,244.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 13,156,884.52 | 22,286,244.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,328,234.52 | 12,817,288.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө | 11,328,234.52 | 12,817,288.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал | 1,828,650.00 | 9,468,956.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,119,561,092.00 | 1,474,972,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 907,160,900.00 | 1,193,041,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,193,041,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 907,160,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,038,095.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,038,095.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 207,362,097.00 | 281,930,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 207,362,097.00 | 281,930,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,259,488,584.15 | 1,507,622,474.85 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,259,488,584.15 | 1,507,622,474.85 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,165,965,555.36 | 1,456,784,548.35 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 644,244,148.00 | 806,697,426.00 |
| 210101 | Үндсэн цалин | 475,176,859.00 | 594,947,316.00 |
| 210102 | Нэмэгдэл | 117,008,222.00 | 159,318,673.00 |
| 210104 | Урамшуулал | 52,059,067.00 | 52,431,437.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 83,633,872.31 | 101,272,780.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,166,065.21 | 69,486,959.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,407,545.19 | 8,126,279.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,156,005.17 | 6,443,903.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,264,024.48 | 1,565,056.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,640,232.26 | 15,650,579.97 |

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|-------------------------|------------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 206,262,097.00 | 210,361,869.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,676,993.00 | 8,824,765.00 |
| 210302 | Түлш, халаалт | 201,327,104.00 | 201,327,104.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 258,000.00 | 210,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,024,895.00 | 19,858,266.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 811,705.00 | 523,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,112,100.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 345,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 510,150.00 | 440,970.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,245,940.00 | 403,750.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 18,489,996.22 |
| 2105 | Нормативт зардал | 48,668,260.50 | 105,165,934.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 862,050.00 | 698,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 47,123,910.50 | 104,371,534.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 682,300.00 | 95,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,333,850.00 | 5,700,144.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,333,850.00 | 5,700,144.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 381,500.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 381,500.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,658,000.00 | 4,453,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,658,000.00 | 2,868,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,585,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 168,758,932.55 | 203,275,028.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 260,000.00 | 29,550,190.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,372,300.00 | 9,051,797.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 167,126,632.55 | 164,673,041.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 93,523,028.79 | 50,837,926.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,242,521.30 | 50,828,650.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,942,521.30 | 50,828,650.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 73,280,507.49 | 9,276.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 73,280,507.49 | 9,276.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (126,770,607.63) | (10,364,130.85) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 5,508,260.29 | 2,105,944.74 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,508,260.29 | 2,105,944.74 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (5,508,260.29) | (2,105,944.74) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (132,278,867.92) | (12,470,075.59) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,124,922,305.80 | 1,474,972,100.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,361,213.80 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,361,213.80 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,361,213.80 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,361,213.80 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,119,561,092.00 | 1,474,972,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 907,160,900.00 | 1,193,041,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,193,041,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 907,160,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,038,095.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,038,095.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 207,362,097.00 | 281,930,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 207,362,097.00 | 281,930,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,113,448,445.80 | 1,329,703,207.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,113,448,445.80 | 1,329,703,207.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,017,325,702.31 | 1,279,472,427.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 644,244,148.00 | 806,697,426.00 |
| 210101 | Үндсэн цалин | 475,176,859.00 | 594,947,316.00 |
| 210102 | Нэмэгдэл | 117,008,222.00 | 159,318,673.00 |
| 210104 | Урамшуулал | 52,059,067.00 | 52,431,437.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 83,633,872.31 | 101,272,780.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,166,065.21 | 69,498,621.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,407,545.19 | 8,101,803.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,156,005.17 | 6,424,383.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,264,024.48 | 1,567,941.74 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,640,232.26 | 15,680,029.79 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 206,262,097.00 | 210,361,869.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,676,993.00 | 8,824,765.00 |
| 210302 | Түлш, халаалт | 201,327,104.00 | 201,327,104.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 258,000.00 | 210,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,944,195.00 | 142,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 669,595.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,112,100.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 345,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,265,300.00 | 142,000.00 |

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------------|------------------------|------------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,552,200.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 51,288,340.00 | 113,965,994.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 901,900.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 48,180,840.00 | 113,965,994.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,205,600.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,222,000.00 | 986,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,122,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 986,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 381,500.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 381,500.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,339,000.00 | 4,776,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,339,000.00 | 2,867,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,908,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,010,550.00 | 41,269,957.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,110,000.00 | 29,135,700.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,900,550.00 | 12,134,257.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 96,122,743.49 | 50,230,780.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,842,236.00 | 50,221,504.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,542,236.00 | 50,221,504.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 73,280,507.49 | 9,276.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 73,280,507.49 | 9,276.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 11,473,860.00 | 145,268,893.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 11,473,860.00 | 45,036,180.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 11,473,860.00 | 45,036,180.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 11,473,860.00 | 45,036,180.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 11,473,860.00 | 45,036,180.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (11,473,860.00) | (45,036,180.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | 100,232,713.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 101,227,713.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|----------------------------------------|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 279,506,769.68 | 1,916,982,677.11 | 181,395,992.74 | | 2,377,885,439.53 |

| | | | | | | |
|-----|--------------------------------------------------|----------------|------------------|------------------|---|------------------|
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 279,506,769.68 | 1,916,982,677.11 | 181,395,992.74 | - | 2,377,885,439.53 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (132,278,867.92) | | (132,278,867.92) |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 279,506,769.68 | 1,916,982,677.11 | 49,117,124.82 | - | 2,245,606,571.61 |
| D01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 279,506,769.68 | 1,916,982,677.11 | 49,117,124.82 | - | 2,245,606,571.61 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 21,643,018.80 | | 21,643,018.80 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 279,506,769.68 | 1,916,982,677.11 | 70,760,143.62 | - | 2,267,249,590.41 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (21,643,018.80) | - | | (21,643,018.80) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,470,075.59) | | (12,470,075.59) |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 279,506,769.68 | 1,895,339,658.31 | 58,290,068.03 | - | 2,233,136,496.02 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--------------------------------------------------|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,474,972,100.00 | 1,374,739,387.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,474,972,100.00 | 1,329,703,207.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,419,778,100.00 | 1,279,472,427.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 872,169,200.00 | 806,697,426.00 |
| 210101 | Үндсэн цалин | 648,679,100.00 | 594,947,316.00 |
| 210102 | Нэмэгдэл | 190,959,900.00 | 159,318,673.00 |
| 210104 | Урамшуулал | 32,530,200.00 | 52,431,437.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 108,936,200.00 | 101,272,780.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,115,000.00 | 69,498,621.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,719,300.00 | 8,101,803.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,975,500.00 | 6,424,383.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,738,800.00 | 1,567,941.74 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,387,600.00 | 15,680,029.79 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 210,371,100.00 | 210,361,869.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,333,900.00 | 8,824,765.00 |
| 210302 | Түлш, халаалт | 201,827,200.00 | 201,327,104.00 |

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------|-----------------------|
| 210303 | Цэвэр, бохир ус | 210,000.00 | 210,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 142,000.00 | 142,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 142,000.00 | 142,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 136,442,600.00 | 113,965,994.50 |
| 210502 | Хоол, хүнс | 136,442,600.00 | 113,965,994.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 986,100.00 | 986,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 986,100.00 | 986,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,124,500.00 | 4,776,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,867,900.00 | 2,867,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,256,600.00 | 1,908,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 79,606,400.00 | 41,269,957.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,221,400.00 | 29,135,700.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,385,000.00 | 12,134,257.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,194,000.00 | 50,230,780.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 55,194,000.00 | 50,230,780.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 55,194,000.00 | 50,221,504.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 9,276.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 45,036,180.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 45,036,180.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 45,036,180.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,474,972,100.00 | 1,474,972,100.00 |
| | | 0 | 0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,193,041,600.00 | 1,193,041,600.00 |
| | | 0 | 0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,193,041,600.00 | 1,193,041,600.00 |
| | | 0 | 0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 281,930,500.00 | 281,930,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 281,930,500.00 | 281,930,500.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 101,227,713.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 69.00 | 69.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 40.00 | 40.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 28.00 | 28.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 527.00 | 525.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 527.00 | 525.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 527.00 | 525.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдээ эрхэмлэн багшаа чадавхжуулан ерөнхий боловсролын үйлчилгээг чанартай хүргэгч баг хамт олон байх, багш ажилтан бүрийн тасралтгүй хөгжил, ёс зүйг баримтлах гэж зорилгоо тодорхойлжээ. Зорилгоо хэрэгжүүлэх дараах зорилтуудыг баталжээ. Үүнд:

- Багш ажилтан бүрийн тасралтгүй хөгжил, ёс зүйг баримтлах;
- Хичээл хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт;
- Чанар сайжруулалт, хүүхдийн хөгжлийн үнэлгээ, үр дүнд бодит үнэлгээ тооцох;
- Орчны аюулгүй байдлыг хангах, эцэг эх ,гэр бүлийн оролцоо хамтын ажиллагаа сайжруулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй ба дараах хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал:

- Боловсролын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, бие даасан аудиторын чиг үүргийг хэрэгжүүлдэг орон тоо байхгүй бөгөөд байгууллагын дотоод хяналт зохион байгуулах журам боловсруулан баталж түүнийг төлөвлөгөөт ажил үйл ажиллагааг явуулахад баримтлан ажилладаг байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2022 онд санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар зориулалт бус зарцуулсан зөрчилд 150.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах 6 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэнг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж хариуг холбогдох газарт хүргүүлсэн байна.

Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудиторын чиг үүрэг бүхий орон тоо байхгүй бөгөөд дотоод хяналт, шалгалтын 5 хүний бүрэлдэхүүнтэй багийг томилсон байна. Тухай баг нь хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж хамт олны хурлаар хэлэлцүүлдэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын ясли нь Булган аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна .

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 0.5 өмнөх оноос 12470.0 мянган төгрөгөөр буюу хувиар өссөн/буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ | |
|----------------------------------------------|---------------------|---------------------|--------------------|
| | | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 101,227.71 | 101,227.71 |
| Авлага | 16,063.00 | - | (16,063.00) |
| Бараа материал | 64,106.19 | 61,516.92 | (2,589.27) |
| Үндсэн хөрөнгө | 2,165,437.38 | 2,070,391.86 | (95,045.52) |
| Нийт хөрөнгө | 2,245,606.57 | 2,233,136.50 | (12,470.08) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,966,099.80 | 2,233,136.50 | 267,036.69 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,966,099.80 | 2,233,136.50 | 267,036.69 |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 101,227.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь улсын төсвөөс олгогдсон санхүүжилтийг төвлөрүүлээгүй мөн орон тоо дутуу ажилласан тул багш нарын цалингаас 65,471.7 мянган төгрөг, хүүхдийн хоолны зардал 22,476.6, НДШ 7,663.4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна. Мөн төсвийн шинэчлэл 2022 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой.

Авлага дансны эхний үлдэгдэл 16,063,0 мянган төгрөгөөр буурсан нь 13,000.0 ухаалаг самбар, 880,0 мянган төгрөгийн таблет, 995.0 мөнгөн төгрөгийн хормын хувцас бэлтгэсэн, 1.188,0 мянган төгрөгийн эсгий хавтангийн авлагыг тус тус барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал 2,589.3 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны жилийн эцсийн тооллогоор цаашид ашиглах боломжгүй болсон 18,489.9 мянган төгрөгийн аж ахуйн материалыг байгууллагын даргын 2022 оны 12-р сарын 27-ний өдрийн А/33 тушаалаар акталсан, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,000.0 мянган төгрөг, эцэг эх сумын сайн малчдаас хандиваар 2,629.5 мянган төгрөг авч нийт 4,629.5 мянган төгрөгийн засварын материал бэлтгэсэн, дотуур байрны сурагчдаас айраг авч борлуулан 1,875.5 мянган төгрөгийн материал бэлтгэн зарцуулсан, БШУЯ-аас 2,930.4 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Нийт үндсэн хөрөнгийн 98.9 хувийг биет хөрөнгө, 0.10 хувийг биет бус хөрөнгө, 1.0 хувийг газар болон бусад хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө 95,045.5 мянган төгрөгөөр буурсан нь үлдэх өртөггүй болсон цаашид ашиглах боломжгүй болсон 9,500.0 мянган төгрөгийн авто машиныг Аймгийн ИТХ-ын XI хуралдааны 2022 оны 09-р сарын 28-ны өдрийн 11/07 тоот тогтоолоор, 74 нэр төрлийн 67,886.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 21 нэр төрлийн 8,296.8 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг Сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 10-р сарын 18-ны өдрийн 10/06 тоот тогтоол, 2022 оны 12-р сарын 19-ний өдрийн 11/14 тоот тогтоолоор тус тус акталж данснаас хассан, Сумын ИТХ-ын 2022 оны 10-р сарын 18-ний өдрийн 10/05 тоот тогтоол мөн 2022 оны 12-р сарын 19-ний өдрийн 11/13 тоот тогтоолоор төсвийн хөрөнгөөр 45,036.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, БСШУЯ-аас 1,489.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,249.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил шилжүүлэн авсан, багш нар эцэг эхийн хандиваар 24,480.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төгсөгч анги 3,000.0 мянган төгрөгийн хүүхдийн амрах саравч барьж хүлээлгэн өгч бүртгэл тайланд тусгасантай тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,321,629.4 мянга, орон нутгийн төсвөөс 281,930.5 үйл ажиллагааны нийт зарлагыг 1,603,559.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх 128,587.8 сая төгрөгөөр бууруулж, 1,374,739.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалингийн зардлыг 121,272.3 мянган төгрөгөөр, НДШ-ийг 15,159.0, нормативд зардлыг 46,960.5 мянган төгрөгөөр бууруулан нь хүүхдийн шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй нь шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,193,041.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 281,930.5 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Сайхан сумын ерөнхий боловсролын сургууль 2022 оны төсвийн тусгай зориулалтын санхүүжилтээс 1,193,041.6 төгрөг, тогтмол зардлын санхүүжилт 281,930.5 мянган төгрөг төвлөснөөс 1,374,739. 387 төгрөгийн зардал гарж, улсын төсвийн дансны үлдэгдэл 101,227.7 мянган төгрөг байна.

Улсын төсвийн харилцах данс 101,227.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь дотуур байрны сурагчид 220 хүүхдээр төсөвлөгдсөн боловч гүйцэтгэлээр 140 хүүхэд хүлээн авч дотуур байрны хоолны зардлыг хэмнэсэн, батлагдсан бүтэц орон тооноос 4 багшийн орон тоо дутуу үйл ажиллагаа явуулсантай холбоотойгоор цалингийн зардал тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-------------------------------|-----------------------|---------------------|---------------------|------------|---------|
| 1 | 71802-80226 | 3,302.70 | 3,302.20 | 0.50 | 99.98 |
| 2 | 71802-80312 | 1,651.30 | 1,606.80 | 44.50 | 97.31 |
| 3 | 71802-81605 | 3,798.10 | 3,770.00 | 28.10 | 99.26 |
| 4 | 71802-81801 | 55,194.00 | 50,221.50 | 4,972.50 | 90.99 |
| 5 | 71802-81806 | 174,617.90 | 147,727.10 | 26,890.80 | 84.60 |
| 6 | 71802-81816 | 37,465.00 | 37,460.90 | 4.10 | 99.99 |
| 7 | 71802-81823 | 7,431.00 | 7,267.90 | 163.10 | 97.81 |
| 8 | 71802-81834 | 748,483.60 | 679,633.40 | 68,850.20 | 90.80 |
| 9 | 71802-81835 | 155,680.10 | 155,406.20 | 273.90 | 99.82 |
| 10 | 71802-81848 | 2,867.90 | 2,867.90 | - | 100.00 |
| 11 | 71802-83603 | 2,550.00 | 2,550.00 | - | 100.00 |
| Улсын төсвийн нийт дүн | | 1,193,041.60 | 1,091,813.90 | 101,227.70 | 91.52 |
| 12 | 71802-80111 | 211,357.20 | 211,357.20 | - | 100.00 |
| 13 | 71802-80112 | 70,573.30 | 70,573.30 | - | 100.00 |
| Орон нутгийн нийт дүн | | 281,930.50 | 281,930.50 | - | 100.00 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 1.5 хувиар буюу 22,124.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн хориглосон заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 50 удаагийн нийт 1,373,721.9 мянган төгрөгийн орлогын мэдээлэл, 12 удаагийн 231,220.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 6.4.8-д заасан 23 удаагийн 61,197.6 мянган төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 14,875.0 мянган төгрөгийн зөрчилд 995.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 13,880.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэнг бүрэн хэрэгжүүлэн хариуг 2022 оны 06 дугаар сарын 09 өдрийн 29, 30 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | /мянган төгрөгөөр/ Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------|-------------------------------|----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 995.0 | 1 | 995.0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 13,880.0 | 1 | 13,880.0 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| Нийт дүн | 2 | 14,875.0 | 2 | 14,875.0 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 670.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 670.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчид 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсний урамшуулал 398.8 мянган төгрөгийг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмын 4.5 дахь “...ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2. Нийт 79.5 мянган төгрөгийн илүү цагаар ажилласан цалин хөлсийг илүү тооцож олгосон нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 дугаар тушаалыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй,

3. Шатахууны зардлыг тооцож олгохдоо автомашины 100 км тутамд зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 192.6 мянган төгрөгийг илүү тооцон олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зэрэг зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

